



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 19 өдөр

Дугаар Д/102

Арвайхээр сум

**Газар ашиглалтын зориулалтад
өөрчлөлт оруулах тухай**

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг, Мэргэд-1 гудамж, 100 тоотод байрлах Баттулгын Төрбатын (ЙА76112016) эзэмшил амины орон сууцны зориулалттай 552м² газрын зориулалтыг 5-8 давхар нийтийн орон сууц, 13 дугаар баг, Төв-4 гудамж, 400а тоотод байрлах Дашнямын Батбаярын (ЙВ87110137) эзэмшил 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай 2030м² газрын зориулалтыг 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц, 13 дугаар баг, П.Лувсандорж-2 гудамж, 213 тоотод байрлах Эс эн кинг энержи ХХК-ний (3572277) эзэмшил 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай 1350м² газрын зориулалтыг 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууцны зориулалттай болгон тус тус өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

8224 11 0221



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2014 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/109

Арвайхээр сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 1 нэгж талбарыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн "Газар эзэмших эрх шинээр олгох тухай" А/702 дугаар захирамжийн хавсралтын С.Батдуламтай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6324 11 0223